

UCS0001-01:2019

## ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага

# ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага



Улаанбаатар хот  
2019 он



**ХОТЫН СТАНДАРТ****Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага**

1. Барилгын талбайн түр хашаа;
2. Явган замын саравч;
3. Барилгын хамгаалалтын хаалт, хашлага;
4. Барилгын хамгаалалтын хүрээ;
5. Авто замын хаалт;
6. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ
7. Барилгын талбайн хог хаягдал
8. Барилгын талбайн ахуйн түр байгууламж /бие засах газар/
9. Ачаа тээврийн үйл ажиллагааны аюулгүй байдлын ерөнхий шаардлага

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

**1. ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ**

- 1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь барилга угсралт, өргөтгөл болон замын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, барилга байгууламжийн шинэчлэлт, сэргээн засварлах ажилд тавих аюулгүйн ерөнхий шаардлага, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах энэ талаар төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.
- 1.2. Барилга угсралтын ажил, замын ажил болон барилгын материалын үйлдвэрлэл, барилга байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, энэ чиглэлээр хяналт тавих байгууллага, инженер техникийн ажилтан мөрдөж хэрэглэнэ.
- 1.3. Энэхүү стандартыг барилгын ажлын аюулгүй байдлын хяналт үзлэг, хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхэд хэрэглэнэ.

**2. НОРМАТИВ ИШЛЭЛ**

Энэхүү стандартад дараах иш татсан хууль, дүрэм журам, барилгын норм ба дүрэм, стандарт баримт бичгүүдийг хэрэглэнэ. Иш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлээс хэрэглэнэ.

- 2.1. Барилгын талбайн түр хашаа MNS 5414:2014;
- 2.2. Хамгаалах хашлага MNS 12.4.007:1981;
- 2.3. Дохионы өнгө, аюулгүйн ажиллагааны тэмдгүүд MNS 12.4.002:85;
- 2.4. Авто замын хаалт MNS 6517:2015;
- 2.5. Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014
- 2.6. Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт БНБД 12-01-09
- 2.7. Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06.-90;
- 2.8. Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04;
- 2.9. Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-04-06;
- 2.10. Ачаа тээврийн автомашин болон чиргүүлийн бүтээлэг MNS 6756: 2019

### 3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 3.11. **Барилгын ажил** – гэж бүх төрлийн барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэлт ба засварын ажил гүйцэтгэх болон тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;
- 3.12. **Барилгын талбай** – гэж барилгын ажил явагдаж байгаа орчин болон тухайн барилгад хэрэглэх материал, эдлэхүүн, бүтээц ба тоног төхөөрөмжийг хураасан агуулах, суурийн гадна талаар чигжих шорооны байрлал объектод ажиллаж байгаа хүнд машин механизмын зогсоол болон түр зам, хашаа түүнчлэн бүх төрлийн түр барилга, шугам сүлжээг хамтатган авч үзэх орон зайг;
- 3.13. **Шинэчлэлт** – гэж барилга байгууламжийн үндсэн овор хэмжээг өөрчлөхгүйгээр үйлдвэрийг технологийнх нь хувьд (тоног төхөөрөмжийг нь солих, шинэчлэх г.м) шинэчилснээр зориулалт буюу техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг өөрчлөхтэй холбогдсон ажил, технологи-зохион байгуулалтын арга хэмжээг;
- 3.14. **Барилга байгууламжийн засвар** – гэж барилгын үндсэн зориулалт болон техникийн үзүүлэлтийг өөрчлөхгүйгээр түүний физик элэгдэл, эдэлгээний хоцрогдлыг арилгах зорилгоор гүйцэтгэх ажил буюу техник–зохион байгуулалтын цогц арга хэмжээг;
- 3.15. **Замын ажил** – авто зам, замын байгууламжийн ашиглалтын ангилал, зэрэглэл, ашиглалтын түвшинг дээшлүүлж, сайжруулах зорилгоор тогтоосон хугацаанд хийх барилгын ажлыг;
- 3.16. **Түр хашаа** – Барилгын ажил явагдаж байгаа дэвсгэр нутаг болон барилга объектын талбайг барилга угсралтын ажил явагдаж байгаа хугацаанд хамгаалах, гадны хүн нэвтрүүлэхгүй байх, хүмүүст сэрэмжлүүлэх зорилготой.
- 3.17. **Явган замын саравч** - Баригдаж буй барилгаас юм унаж гудамжны явган хүний замаар (хашааны хажуугаар) зорчигчдыг аюул ослоос хамгаалах зориулалттай.
- 3.18. **Хамгаалалтын хаалт, хашлага** – Барилга байгууламжийг барих засварлах үед өндрөөс хүн унагахгүй хамгаалах зориулалттай хамгаалалт.
- 3.19. **Хамгаалалтын хүрээ** – Барилга байгууламжийг барих засварлах үед өндрөөс хүн унагахгүй хамгаалах зориулалттай хамгаалалт.
- 3.20. **Хориглох тэмдэг** – Ямар нэг тодорхой үйлдлийг хориглоход зориулагдана.
- 3.21. **Анхааруулах тэмдэг** – Үүсэж болзошгүй аюулын талаар ажиллагсдыг анхааруулахад зориулагдана.
- 3.22. **Заах тэмдэг** – Төрөл бүрийн объект, төхөөрөмж болон эмнэлгийн тусламж үзүүлэх цэг, цайны газар, галын пост, гал унтраагуур, гал гарсан тухай мэдээлэх байр, агуулах мастерын газар эргийн байрлалыг заахад зориулагдана.
- 3.23. **Дохионы өнгө** – Аюул бүхий орчинд ажиллагсдын анхаарал татах, үүсэж болзошгүй аюулыг урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тодорхой үйлдлийг гүйцэтгэхийг зааж, зөвшөөрөхөд болон шаардлагатай мэдээлэлд зориулагдана.
- 3.24. **Авто замын хаалт** – Нийтийн эзэмшлийн болон төр, хувийн байгууллагын зам талбайд тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, оролт гаралт, тодорхой хугацаанд замын ажил гүйцэтгэх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулж зохион байгуулах зориулалттай хаалт.




#### 4. УДИРТГАЛ

- 4.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь барилга угсралт, өргөтгөл болон замын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, барилга байгууламжийн шинэчлэлт, сэргээн засварлах ажилд тавих аюулгүйн ерөнхий шаардлага, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах энэ талаар төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.
- 4.2. Барилга байгууламж, замын ажлын үеийн зохион байгуулалттай холбогдох захиалагч ба барилга угсралтын байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хариуцлагын тогтолцоог тодорхой болгосноор барилгын ажлаас үүдсэн эрсдэлийг бууруулах.
- 4.3. Барилга байгууламжийн ажлыг «Барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журам»-д заасны дагуу барилга байгууламжийн угсралтын ажлыг эхлэх болон үргэлжлүүлэн гүйцэтгэх зөвшөөрлийг авсан нөхцөлд эхэлнэ (БНБД 12-01-09).
- 4.4. Барилгын үйлдвэрлэлд бэлтгэх ажлын хүрээнд, барихаар төлөвлөж байгаа барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгийг нарийвчлан судалж, барилгын ажил гүйцэтгэх нөхцөл, байдалтай танилцсаны үндсэн дээр байгаль орчин, барилгын ажлын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан арга хэмжээг авна.
- 4.5. Барилгын талбай, ажлын аюултай бүс зэргийг газар дээр нь зааж тэмдэглэх бөгөөд хамгаалалтын хашааг барьж орц, гарцыг тогтоосон байх ёстой (БНБД 12-01-09 -ийн 7.7 -т).
- 4.6. Нийтийн эзэмшлийн болон төр хувийн хэвшлийн байгууллагын зам талбайд тодорхой хугацаанд замын ажил гүйцэтгэх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, хаах, зам талбайд тавьж байрлуулах үйл ажиллагаанд хамаарна.
- 4.7. Барилгын талбайн гол хаалганы дээр тусгай самбар байрлуулж түүнд объектын нэр, захиалагч /хөрөнгө оруулагч/ ба гүйцэтгэгчийн нэр, уг барилгын даамал, зөвлөх болон мэргэжлийн хяналтын байгууллагаас уг объектын хариуцагч хяналтын байцаагчийн нэр, харилцах утас, барилга эхлэх, дуусах хугацааг томоор заавал бичсэн байх ёстой (БНБД 12-01-09 -ийн 7.8 -т).
- 4.8. Бичвэр нь гудамжны хөдөлгөөнд оролцогчдод саадгүй уншигдах хэмжээнд байна (БНБД 12-01-09 -ийн 7.8 -т).
- 4.9. Баригдаж буй барилга байгууламжийн явцад гарч болох сөрөг нөлөөллийн улмаас орчны оршин суугчид, хүрээлэн буй орчинд хор нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх улмаар таслан зогсоох ажлыг «Барилгын тухай» хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулах нь хот, орон нутгийн засаг захиргааны хяналтын гол зорилго болно (БНБД 12-01-09 -ийн 8.9 -т).

## 5. БАРИЛГЫН ТАЛБАЙН ТҮР ХАШАА

Барилгын талбайн түр хашааг барилга угсралт, өргөтгөл, инженерийн шугам сүлжээний ажил, барилга байгууламжийн гадна засварын ажил эхлэхийн өмнө барилгын үйлдвэрлэлд бэлтгэх ажлын хүрээнд орчны аюулгүй байдлыг барилга явагдаж байгаа хугацаанд хангах зорилгоор барих бөгөөд барилгын түр хашаа нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



Зураг №1. Барилгын талбайн түр хашааны харагдах байдал

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол "Тийм" хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол "Үгүй" хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №1. Шалгуур үзүүлэлтүүд


№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Барилгын талбайн түр хашаа бүрэн хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хийцийн стандарт геометр хэмжээ тохирч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Бат бөхийн шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

### 5.1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1.1. Барилгын түр хашаа нь өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй байвал зохино.
- 5.1.2. Түр хашааг самбаран болон сараалжин /торон/ хаалттай хийж болно.
- 5.1.3. Хашааны шон хоорондын зай нь 1.2; 1.6; 2.5 м байх бөгөөд 6.0 м-ээс ихгүй байна.
- 5.1.4. Хашаа нь тээврийн хэрэгсэл орох, гарах хаалга мөн хүмүүс орж гарах үүдтэй байна.
- 5.1.5. Барилгын түр хашаа цайвар саарал болон цагаан өнгөтэй байна. RGB 204,204,204,





Зураг №2. Барилгын талбайн түр хашааны бэхлэгээ, суурилуулалт

## 5.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА

- 5.2.1. Барилгын түр хашааг 10 жилээс багагүй хугацаагаар ашиглахаар тооцож бат бөх, зөөж тээвэрлэхэд хялбараар үйлдвэрлэвэл зохино.
- 5.2.2. Хашааны бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар мөн эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад энгийн байвал зохино.
- 5.2.3. Барилгын хашаанд нөлөөлөх салхины хурд, салхины ба цасны ачааллыг тооцож бат бэх хийвэл зохино /БНБД 2.01.01-93, БНБД 2.01.07-90/.

## 5.3. БЭХЭЛГЭЭ СУУРИЛУУЛАЛТ

- 5.3.1. Барилгын түр хашааг газарт ухаж суурилуулах ба шонг газарт зоох боломжгүй тохиолдолд тулаас бүхий хүндрүүлэгч дээр суурилуулж болно /Зураг №2/.
- 5.3.2. Хашааны шонг 1м хүртэл гүнд суулгана. Хашааны хүндрүүлэгчийн жинг хашааны үндсэн хийц эдлэхүүний нийт жингээс хамааруулан сонгоно /Хүснэгт №3/.

Зураг №3. Түр хашааны хүндрүүлэгч


Хүндрүүлэгчийн жин /кг/			
16	25	32	50
64	100	128	150

## 5.4. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ

5.4.1. Барилгын түр хашааг олон улсын стандартын шаардлага хангасан мөн барилгын түр хашаа зориулалтаар зохиогчийн эрхийн баталгаа бүхий шинэ дэвшилтэт арга технологи шингэсэн бүтээгдэхүүн ашиглан барьж, ашиглаж болно.

## 6. ЯВГАН ЗАМЫН САРАВЧ

Барилгын талбайн явган замын саравчийг барилга угсралт, өргөтгөл, инженерийн шугам сүлжээний ажил, барилга байгууламжийн гадна засварын ажил эхлэхийн өмнө барилгын үйлдвэрлэлд бэлтгэх ажлын хүрээнд орчны аюулгүй байдлыг барилга явагдаж байгаа хугацаанд хангах зорилгоор барих бөгөөд барилгын талбайн явган замын саравч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



Зураг №4. Явган замын саравчны харагдах байдал

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №2. Шалгуур үзүүлэлтүүд


№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Явган замын саравч хашааны уртын дагуу бүрэн хийгдсэн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Саравч явган замын өргөнийг бүрэн халхалж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Саравчинд дээвэр хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Саравчинд хашигч хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Саравчинд бариул хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Саравчинд шал хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хийцийн стандарт геометр хэмжээ тохирч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Даацын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.



## 6.1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 6.1.1. Явган замын саравч нь өнгө үзэмж сайтай, эвдрэл гэмтэлгүй байвал зохино.
- 6.1.2. Саравч нь явган зорчих хэсгийн өргөнийг бүрэн гүйцэд халхалсан байна.
- 6.1.3. Саравчны дээвэр нь барилга тал уруугаа  $20^\circ$ -аас багагүй налуутай байвал зохино.
- 6.1.4. Саравчтай хашааны нам хэсгийн өндөр нь хамгийн багадаа /шалнаас дээш/ 2.1 м-ээс дээш байх шаардлагатай.
- 6.1.5. Саравчны өндрийг барилгын өндөр болон орчны нөхцөл байдлын шаардлагаас хамааруулан нэмэгдүүлж болно.
- 6.1.6. Саравч хийгдсэн хэсэгт явган хүний замыг газраас 15 см өргөж шал хийх шаардлагатай.
- 6.1.7. Саравчны тулаасны дотор талд бариул ба хашигчийг хийх бөгөөд хүний гарыг гэмтээхгүй байх нөхцөлийг хангасан байна.



Зураг №5. Явган замын саравчны харагдах байдал

## 6.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА


- 6.2.1. Саравчны бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар байхаас гадна эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад энгийн байвал зохино.
- 6.2.2. Барилгын явган замын саравчинд нөлөөлөх салхи ба цасны ачааллыг тооцож, бүтээцийг бат бэх хийх бөгөөд, дээвэрт салангид бүтээцийг нийлүүлэн хэрэглэсэн тохиолдолд бүтээцийн хөндлөн болон уртын дагуу эсрэг чиглэлээр хүчитгэл хийж байрлуулна. /БНБД 2.01.01-93, БНБД 2.01.07-90/.
- 6.2.3. Саравчны шал нь  $200\text{кг}/\text{м}^2$  хүртэлх ачааллыг даах чадвартай байх ёстой.

## 6.3. БЭХЭЛГЭЭ СУУРИЛУУЛАЛТ

- 6.3.1. Явган замын саравчны дээвэр нь явган зорчих хэсгийн /шал/ өргөнөөс 50-аас 100мм илүү гарч байвал зохино.
- 6.3.2. Саравчны шалны өргөн нь хотод 2.0м, орон нутагт 1.2м-ээс багагүй байвал зохино.
- 6.3.3. Саравчны шалны банзны хоорондох завсар нь 5мм-ээс илүүгүй байна.
- 6.3.4. Гудамжны талд нь шалнаас 0.5м -ийн өндөрт хашигч, хашигчаас дээш 0.5м -ийн өндөрт бариул хийж өгнө.

## 7. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГ

Аюулгүй ажиллагааны тэмдгүүд нь аюул бүхий орчинд ажиллагсдын анхаарал татах, үүсэж болзошгүй аюулыг урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор тодорхой үйлдлийг гүйцэтгэхийг зааж, зөвшөөрөхөд болон шаардлагатай мэдээллийг өгөхөд зориулагдана.



Зураг №6. Аюулгүй ажиллагааны тэмдэг болон барилгын мэдээллийн самбар

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №3. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Аюулгүйн ажиллагааны тэмдгүүд стандартын дагуу хэлбэр хэмжээ, өнгө нь тохирч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Барилгын мэдээллийн самбарын мэдээлэл бүрэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Аюулгүйн ажиллагааны тэмдгүүдийг нийтэд харагдахуйц зөв байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Барилгын мэдээллийн самбар хуучирч муудаагүй, эвдрэл гэмтэлгүй байна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.



## 7.1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1.1. Аюулгүй ажиллагааны тэмдгийг ажиллагсдад аюул учруулж болзошгүй байранд, мөн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж дээр байрлуулна.
- 7.1.2. Аюулгүй ажиллагааны тэмдгүүд нь орчин тойрондоо тод содон, хүмүүст харагдахаар байрласан байх ёстой.
- 7.1.3. Дохионы өнгө, зориулалт:
- 7.1.3.1. Улаан – Хориглох, шууд аюул учруулах байдал, гал унтраах хэрэгсэл
- 7.1.3.2. Шар – Анхааруулах аюул учирч болзошгүй байдал
- 7.1.3.3. Ногоон – Сануулах, аюулгүй байдал
- 7.1.3.4. Хөх – Заах, мэдээлэх
- 7.1.4. Дохионы өнгө хэрэглэх журмыг хэрэгжүүлэхдээ MNS 12.4.002:85: “Дохионы өнгө, аюулгүйн ажиллагааны тэмдгүүд” стандартад нийцүүлэх шаардлагатай.
- 7.1.5. Барилгын мэдээллийн самбарын хэмжээ нь 2х3м түүнээс дээш хэмжээтэй байна. /Зураг №7/
- 7.1.6. Барилгын мэдээллийн самбарт байх ёстой мэдээллүүд:
- 7.1.6.1. Тухайн барилга байгууламжийн захиалагч, ерөнхий гүйцэтгэгчийн нэр;
- 7.1.6.2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, талбай зохион байгуулалтын зураг;
- 7.1.6.3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээний зураг;
- 7.1.6.4. Барилгын эхлэх болон дуусах хугацааг тодорхой бичиж яаралтай үед холбогдох талбайн ерөнхий инженер, талбайн хөдөлмөр аюулгүй байдлыг хариуцсан инженерийн нэр, холбоо барих утасны дугаарыг тэмдэглэнэ; /Зураг №8/



Зураг №7. Барилгын мэдээллийн самбар



Зураг №8. Аюулгүй ажиллагааны тэмдэг


## 7.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА

- 7.2.1. Дохионы өнгө гадаргуу нь аюулгүй ажиллагааны тэмдгийн нэгэн адил өнгө, тэмдгийн утга санааг тод илэрхийлсэн байх.
- 7.2.2. Шөнийн цагт эсвэл үзэгдэх орчин хязгаарлагдмал үед хэрэглэгдэх тэмдгүүд нь гэрэлтүүлэгтэй, гэрэл цацруулагчтай байх.
- 7.2.3. Хавтгай хийцтэй самбарыг 0.5-аас 1.5мм-ийн өргөнтэй төмрөөр хийж гүйцэтгэнэ. Мөн хуванцар, модоор хийж болох бөгөөд энэ нь цаг агаарын ямар ч нөхцөлд чанараа алдахгүй бат бөх байх шаардлагатай.
- 7.2.4. Тэмдэг, хүснэгт, самбарыг бэхлэхэд зориулагдсан хэрэгсэл нь саарал эсвэл мөнгөлөг саарал өнгөтэй байх ёстой.

10 Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар

## 8. БАРИЛГЫН ХАМГААЛАЛТЫН ХААЛТ, ХАШЛАГА

Барилгын хамгаалалтын хаалт, хашлага нь барилга угсралт, өргөтгөл, инженерийн шугам сүлжээний ажил, барилга байгууламжийн гадна засварын ажлын үед орчны аюулгүй байдал мөн байнгын хамгаалах хашлагагүй барилгын хучилт, тэдгээрийн ирмэг зах уруу хүн унахаас болгоомжлох зорилгоор барих бөгөөд барилгын хамгаалалтын хаалт, хашлага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



Зураг №9. Барилгын хамгаалалтын хаалт, хашлагын харагдах байдал

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №4. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Хамгаалалтын хаалт, хашлагын барилгын эргэн тойронд бүрэн хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Баригдаж буй барилга уруу орох хаалганууд хамгаалалтын саравчаар бүрэн хамгаалагдсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хамгаалалтын хаалт хийх шаардлагагүй үед хамгаалалтын бүсийг ашиглаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Угсралтын шат 10м тутамд түр зогсож амрах тавцан тоноглол хийцийн стандарт хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Хөдөлгөөнгүй хийцүүд баригдаж байгаа барилгад бат бэх бэхлэгдсэн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Хамгаалалтын торны гадна талд бэхлэгээний тулгуур суурилуулах хэмжээ тохирч байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хамгаалалтын торны материалын бүрэн бүтэн байдал, стандарт хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Даацын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.



## 8.1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хэрэглэх дүрэм

- 8.1.1. Хашлага нь ажил гүйцэтгэх хугацааны турш хяналт тавьж байх зориулалттай, ажил дууссаны дараа хааж түгжигддэг явган болон дааман хаалгатай байна.
- 8.1.2. Барьж байгаа барилга байгууламж руу орох хаалганууд нь барилгын хананаас 2м-ээс багагүй өргөнтэй саравчаар дээд талаасаа заавал хамгаалагдсан байна.
- 8.1.3. Барилгын дээврийн налуу  $20^{\circ}$ - аас их нөхцөлд ажилчдыг хамгаалалтын бүстэй ажиллана.
- 8.1.4. 1.3м-ээс дээш өндөрт хучилт, хучлага дээр байрлаж байгаа ба өндрөөс унаж болох бүсийн хилээс (ирмэгээс) 2 м-ээс багагүй зайд байгаа ажлын байр болон түүн рүү хүрэх замыг хамгаалалтын хаалтаар хашиж өгвөл зохино.
- 8.1.5. Харин 2м -ээс илүү зайд байгаа бол ГОСТ 12.4.059 -ын шаардлагын дагуу дохиололтой хаалт хийж өгөх ёстой.



Зураг №10 Барилгын хамгаалалтын хаалт, хашлаганы бэхэлгээ, суурилуулалт

## 8.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА

- 8.2.1. Хамгаалах хашлагын бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар мөн эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад энгийн байвал зохино.
- 8.2.2. Хамгаалах хашлагын үндсэн бүх элементүүдийн бат бэхийн болон хашлагыг нийтэд нь хэвтээ ба босоо чиглэлд жигд тархсан 40кг. х/м норматив ачааг хашлагын бариул дээр үйлчлүүлж тогтворт чанарыг нь тооцсон байна.
- 8.2.3. Хэт ачааллын коэффициентийг 1.2 -оор авах ёстой.
- 8.2.4. Хамгаалах хашлагын хийцийн элементүүд нь 20кг -аас ихгүй жинтэй байна.
- 8.2.5. Хамгаалалтын хашлагын торны хэмжээ галд тэсвэртэй материалтай байх бөгөөд торны нүхний оёдлын зай 7.5мм -ээс багагүй байна.

## 8.3. БЭХЭЛГЭЭ СУУРИЛУУЛАЛТ

- 8.3.1. Барилга байгууламжийн тогтвортой хөдөлгөөнгүй хийцүүдэд хамгаалах хашлагыг бэхлэх зангилаануудын хоорондын зай нь 6 метрээс ихгүй байх ёстой.
- 8.3.2. 6 метр ба түүнээс өндөр шатнаас ажил гүйцэтгэх нөхцөлд ажлын /дээд, доод/ хамгаалалтын 2-оос доошгүй тавцан/хучилттай/ байх ба ажлын байр нь барилга, байгууламжийн хананд тулж байрласан байхаас гадна ажлын тавцангаас 2м-ээс илүүгүй өндөрт байрлах шатны тавцангаар хамгаалагдсан байвал зохино.


8.3.3. Угсарч байгаа эдлэхүүнээс дүүжилж тогтоох 10м -ээс өндөр угсралтын шатны 10м тутамд түр зогсож амрах тавцан тоногловол зохино.

#### 8.4. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ

Барилгын хамгаалалтын хаалт, хашлагыг олон улсын стандартын шаардлага хангасан мөн хамгаалалтын хаалт, торны зориулалтаар зохиогчийн эрхийн баталгаа бүхий шинэ дэвшилтэт арга технологи шингэсэн бүтээгдэхүүн ашиглан барьж, ашиглаж болно.

### 9. БАРИЛГЫН ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭ

Барилгын ханын өргийн өндөр, өрөгчдийн зогсож ажиллах түвшингөөс дээш 0.7м болтол эсвэл уг түвшингөөс доош газрын /хүчилт/ түвшин хүртэл 1,3м-ээс өндөр болмогц ажлын байранд хашлага ба гадна байрлалын торон хүрээ хийж ажилчдыг унахаас хамгаалах зорилготой бөгөөд барилгын хамгаалалтын хүрээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:



Зураг №11. Барилгын хамгаалалтын хүрээний харагдах байдал

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №5. Шалгуур үзүүлэлтүүд


№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Хамгаалалтын хүрээ уртын дагуу бүрэн хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хамгаалалтыг хүрээний өргөний хэмжээ барилгын аюулгүйн бүсэд багтсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хамгаалалтын 2 дугаар хүрээний өргөний хэмжээ болон хүрээг тоноггосон өндөр барилгын аюулгүйн бүсэд багтсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Хамгаалалтын торны материалын бүрэн бүтэн байдал, стандарт хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Даацын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.



## 9.1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 9.1.1. Хамгаалалтын хүрээгээр зөвхөн 7м-ээс хэтрэхгүй өндөртэй барилгын гадна хана өрж болно. Гэхдээ барилгын эргэн тойронд аюултай бүсийн хил, тэмдэг тавина.
- 9.1.2. Өндөрт ажил гүйцэтгэж байгаа үед ажлын байрны доод хэсэгт аюулгүй бүсийг гаргаж өгөх хэрэгтэй. /БНБД 12-04-03/
- 9.1.3. Өндрийн нэг чиг шугамын дагууд хэд хэдэн ажлыг нэгэн зэрэг хийх тохиолдолд дээр нь байрлаж байгаа ажлын байрнаас 6 м-ээс ихгүй зайд доод талын ажлын байрыг (дэвсгэр банз, тор, саравч зэрэг) хамгаалалтын төхөөрөмжөөр тоноглон байвал зохино.
- 9.1.4. Ханын гадна талын эхний хамгаалалтын хүрээг нь газрын түвшнгээс дээш 6м-ээс хэтрэхгүй зайд, зайгүй шалавчтай хийх бөгөөд өргийн ажил дуустал энэ хүрээг буулгахгүй.
- 9.1.5. Хамгаалалтын хүрээн дээр унасан барилгын хогийг цэвэрлэх болон хүрээг дээш нь шилжүүлж барих угсралтын ажилчдыг дүүжин шат эсвэл сунадаг люлькигээр тоноглож ажиллуулна.
- 9.1.6. Өндөрт ажиллах ажилчдыг дүүжин шат буюу люлькинээс хамгаалах бүсээр оосорлоно.
- 9.1.7. Хамгаалалтын хүрээн дээгүүр угсрагчдыг явуулах болон материал хураахыг хориглоно.



Зураг №12. Хамгаалалтын хүрээ

## 9.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА

- 9.2.1. Хамгаалалтын хүрээний бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар мөн эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад энгийн байвал зохино.
- 9.2.2. Хүрээг тухайн бүс нутгийн цасны ачааллаас гадна тулгууруудынх нь /хананд бэхэлсэн/ голд үйлчлэх 1600Н /160кгс/-ээс багагүй төвлөрсөн ачааллыг даахаар тооцсон байна.
- 9.2.3. Торны нүхний хэмжээ 80-100мм -ээс багагүй байх бөгөөд утасны өргөн нь 4-6мм-ээс багагүй байна.

### **9.3. БЭХЭЛГЭЭ СУУРИЛУУЛАЛТ**

- 9.3.1. Хүрээнээс доорх ханын хэсэг болон хүрээний хавтгай хоёр хоорондоо  $11^{\circ}$ -ын өнцөг үүсгэхээр байх ба хүрээний шалавч /тороор хийж болно/ хана хоёрын хооронд 50мм-ээс хэтрэхгүй зайтай байна.
- 9.3.2. Эхний хүрээнээс дээш 6-7м-т хоёрдугаар хүрээг тоноглох ба энэ хүрээний шалавчийг 50мм x 50мм-ээс илүүгүй нүдтэй төмөр тороор хийж болно. Цаашид өрөг явагдаж буй түвшингөөс доош мөн л 6-7м -ийн түвшинд мөнөөх 2 дугаар хүрээг дээшлүүлэн байрлуулна.


### **9.4. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ**

Барилгын хамгаалалтын хүрээг олон улсын стандартын шаардлага хангасан мөн хамгаалалтын хүрээ, торны зориулалтаар зохиогчийн эрхийн баталгаа бүхий шинэ дэвшилтэт арга технологи шингэсэн бүтээгдэхүүн ашиглан барьж, ашиглаж болно.



## 10. АВТО ЗАМЫН ХААЛТ, ХАШИЛТ, ЧИГЛҮҮЛЭХ ХЭРЭГСЛҮҮД

Авто замын ажил, гүүрийн барилга байгууламж, тэдгээрийн засвар арчлалт, нийтийн эзэмшлийн болон төр, хувийн байгууллагын зам талбай, инженерийн шугам сүлжээний худгуудад гүйцэтгэж буй ажилд тээврийн хэрэгсэл ба явган зорчигчид, тухайн газар дахь замын ажилчдын аюулгүй байдлыг хангах зорилготой.



Зураг №13. Авто замын хаалт, хашигч, чиглүүлэх хэрэгслүүд

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №6. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Засварын ажил тэмдгийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой тэмдгийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Шаардлагатай нэмэлт тэмдгүүдийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Хаших байгууламжуудыг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Чиглүүлэгч байгууламжийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Дарцагтай олс ба туузыг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Замын тэмдгүүдийн материалын бүрэн бүтэн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

### 10.1. ХЭРЭГЛЭХ ДҮРЭМ

10.1.1. Замын ажил явагдаж буй зам, гудамжны явж болох хэсэг / тусгаарлах зурвас, явган зам, явган хүний зам/ урт ба өргөнөөр хязгаарлагдсан хэсгийг замын ажил гүйцэтгэх бүсэд тооцно.

10.1.2.Зам засварын ажил хийх, хөдөлгөөнд онцгой горим тогтоох зэргээр түр зуур тавьж хэрэглэсэн замын хөдөлгөөн зохион байгуулалтын техник хэрэгслүүдийг шаардлагагүй болсны дараа нэн даруй авна. Ингэхдээ замын тэмдэг, гэрлэн дохиог тусгай бүрээс /гэр/ -ээр хааж үйлчлэлийг нь зогсоож болно.

10.1.3.Зам дээр засвар, үйлчилгээний ажил хийх болон хөдөлгөөний зохион байгуулалтад түр зуурын буюу шуурхай өөрчлөлт оруулах үед зөөврийн суурьтай тэмдгийг зорчих хэсэг, хөвөө болон тусгаарлах зурвас дээр байрлуулж болно.

<p>Засварын ажил</p> 	<p>“Засварын ажил” тэмдгийг замын зорчих хэсэг, хөвөө, тусгаарлах зурвас дээр ямар нэгэн ажил хийж буй хэсгийн өмнө байрлуулна. Тэмдгийг давтан тавихдаа ажил хийж буй хэсгийн шууд өмнө байрлуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд 7.2.а нэмэлт тэмдгээр уг хэсгийн үргэлжлэх зайг заана.</p>
<p>Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой</p> 	<p>«Явган зорчигчийн хөдөлгөөн хориотой» тэмдгийг явган зорчигчийн тээврийн хэрэгсэлд зориулсан хонгил, явган хүний замгүй гүүр, хиймэл байгууламж, засвартай замын хэсэг гэх мэт) газарт явган зорчигчдын хөдөлгөөнийг хориглоход хэрэглэнэ.</p>
<p>Нэмэлт тэмдэг</p> 	<p>MNS 4596:2014 Нэмэлт тэмдэг 7.2а Тэмдгийг давтан тавихдаа ажил хийж буй хэсгийн шууд өмнө байрлуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд Үйлчлэх хүрээ нэмэлт тэмдгээр уг хэсгийн үргэлжлэх зайг заана.</p>
<p>Заах тэмдэг</p> 	<p>MNS 4596:2014 Заах тэмдэг, Тэнхлэгийн дагуу байрласан хашилтын эхлэл, мөн аюулгүйн ба чиглүүлэгч арал болон зорчих хэсэг дээрх бусад төрлийн саадыг тойрч гарах чигийг заахад хэрэглэнэ.</p>
<p>Хаших байгууламжууд</p> 	<p>“Хаших байгууламжууд”</p> <p>Замын ажил гүйцэтгэх бүсийг хаших, зам талбай, гудамжинд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний урсгалыг хуваах ба чиглэлийг өөрчлөх зорилгоор хэрэглэнэ.</p>




<p>Чиглүүлэгч байгууламжууд</p> 	<p>“Чиглүүлэгч байгууламжууд”</p> <p>Хөдөлгөөнийг тэмдэглэх, тээврийн урсгалыг хуваах ба хазайлгахад конусан хаалтыг хэрэглэнэ. Замын хамгаалалтын зурвасын бүсэд, холдуулах бүсэд ба ажил гүйцэтгэх бүсэд конусан хаалтын хоорондын зай 6-7м байна.</p>
<p>Олс, хязгаарлалтын тууз</p> 	<p>Олс ба туузыг явах хэсэг болон явган хүний замын гадаргуугаас 1,2-1,5м-ийн өндөрт байрлуулна.</p>
<p>Олс, дарцагт тууз</p> 	<p>Дарцагтай олсыг автомашины зам ба гудамжинд замын ажил гүйцэтгэх бүсийн заагийг тэмдэглэх зорилгоор хэрэглэнэ. Дарцагтай олсыг хаших байгууламж байрлуулах шугамаар байрлуулна.</p>

## 11. БАРИЛГЫН ТАЛБАЙН ХОГ ХАЯГДАЛ БОЛОН ОРЧНЫ БОХИРДОЛ

Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, засвар үйлчилгээний гүйцэтгэж буй ажлын үед иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилготой.

Захиалагч, гүйцэтгэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэр, норматив баримт бичигт тулгуурлан барилгын менежментийг хангана.



Зураг №14. Барилгын талбайн хог хаягдал болон орчны бохирдол / Барилгын хог хаягдлын менежмент/

Гүйцэтгэгч байгууллага нь хүрээлэн буй орчны байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах, оршин суугчдын аюулгүй амьдрах нөхцөлийг хангах зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №7. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Барилгын талбай болон түүний гаднах 10 метрийн бүсийг цэвэрлэсэн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хаягдал усыг зайлуулахад газрын гадаргыг гэмтээхгүй байх нөхцөлийг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Барилгаас гарсан хогийг ангилан ялгаж тодорхой цэгт хураасан байдал, хогийг зориулалтын хогийн цэгт хүргэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Барилгын аюултай хог хаягдлыг гэрээ байгуулан нийлүүлэх цэгт хүргэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



5	Өрөмдлөгийн ажлын явцад газрын гүний усыг ил гадаргад асгаж алдахыг таслан зогсоосон эсэх Үйлдвэрлэл, ахуйн бохир усыг харьяа байгууллагуудтай гэрээ хийж зохистой зайлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Барилгыг барих явцад тухайн барилгын талбайд үүссэн түр шороон овоолго, замын сэтлэлтийг ачаа тээвэрлэлт, барилгын ажилд хүндрэл учруулахгүйгээр тодорхой техникийн шийдэл гаргаж зохион байгуулан гүйцэтгэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Хог хаягдлын менежмент төлөвлөгөө биелсэн байдал		


ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.

### 11.1. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

- 11.1.1. Барилгын хог хаягдлыг нутгийн захиргааны байгууллагын зохих албадтай тохиролцсоноор нэр төрлөөр нь тусгайлан ангилж хаях цэгийг тогтоох бөгөөд барилгын талбайд хог цуглуулах ба машин техникийг угаах угаалгын байрыг заавал байгуулж ажиллуулна.
- 11.1.2. Хүрээлэн буй орчиндоо утаа, тоос, хэт чанга дуу чимээ, доргио чичиргээ гаргах технологиос татгалзаж шинэ дэвшилтэт технологи ашиглах шаардлагатай.
- 11.1.3. Орц гарц болон эдгээр хүндрэлтэй орчныг шөнийн цагт сайтар гэрэлтүүлбэл зохино.
- 11.1.4. Барилгын ажил дууссаны дараа түр барилга байгууламжийг нүүлгэж гарсан хог хаягдлыг заавал зайлуулна.
- 11.1.5. Хог хаягдлын менежментэд хөрсний бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг заавал тусгасан байх шаардлагатай.

## 12. БАРИЛГЫН ТАЛБАЙН АХУЙН ТҮР БАРИЛГА /БИЕ ЗАСАХ ГАЗАР/

Барилгын үйлдвэрлэлд бэлтгэх ажлын хүрээнд, барихаар төлөвлөж байгаа барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгийг нарийвчлан судалж, барилгын ажил гүйцэтгэх нөхцөл, байдалтай танилцсаны үндсэн дээр барилгын талбайд ажилчдад үйлчлэх захиргаа, аж ахуй болон үйлдвэрлэл, соёл, ахуйн үйлчилгээ, орон сууцны түр барилга байгууламжийг барих шаардлагатай бөгөөд ажилчдын эрүүл аюулгүй байдлыг хангах зорилготой. Удаан хугацаагаар үргэлжлэх хотхон төслийн барилгын ажлаас бусад нөхцөлд мөн барилгын ажил үргэлжлэх хугацаанаас хамаарч зөөврийн бие засах газар байрлуулна.



Зураг №15. Барилгын талбайн ахуйн түр барилга/ Зөөврийн бие засах газар/

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

Хүснэгт №8. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Зөөврийн бие засах газрыг ашиглах аюулгүй ажиллагааны зааврыг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Шалыг гулгаж халтирахгүй материалаар стандартын дагуу хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Угаагуурыг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Ариун цэврийн цаас тогтоогчийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Зөөврийн бие засах газрыг эрүүл ахуй, зориулалт, стандартын дагуу зохистой ашигласан байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Зөөврийн бие засах газрын өдөр тутмын ашиглалт, эдэлгээний байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Зөөврийн бие засах газрын материалын бүрэн бүтэн байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

ТАЙЛБАР: Дээрх үндсэн шалгах үзүүлэлтүүд бүгд тийм гэж тэмдэглэгдсэн байх шаардлагатай.



## **12.1 ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

- 12.1.1. Барилгын ажилчдыг орон сууц, хоол хүнс, соёл-ахуйн зориулалттай түр барилга байгууламжаар хангах төлөвлөгөө нь барилгын зохион байгуулалтын төсөл /ЗБТ/-д тодорхой зааж тусгагдсан байна.
- 12.1.2. Түр барилгыг дараах байдлаар ангилна. Үүнд:
- 12.1.2.1.1. Үйлдвэрлэлийн (арматурын, бетон хольцын, зуурмагийн, мужааны цех тасаг г.м)
  - 12.1.2.1.2. Агуулахын (ил ба цоожтой, саравч г.м)
  - 12.1.2.1.3. Ахуйн (контор, ажилчдын хувцас солих өрөө, гуанз цайны газар, сууц, эмнэлгийн цэг, жорлон, соёлын, дулаацах байр г.м)
  - 12.1.2.1.4. Инженерийн сүлжээ (түр ус, ариутгах татуурга, эрчим хүч, дулаан ба шахсан агаарын г.м )
  - 12.1.2.1.5. Эдгээр түр барилга байгууламж нь тухайн барилгын төлөвлөлтийн норм ба дүрмийн шаардлагыг (барилгын галын аюулгүйн, эрүүл ахуйн) бүрэн хангасан байвал зохино.
- 12.1.3. Түр барилга байгууламжийн тоо, хүчин чадлыг ЗБТ болон барилгын талбайн зохион байгуулалтын зураг төсөлд стандартын дагуу тооцоогоор тодорхойлж тусгаж өгнө.
- 12.1.4. Барилгын захиалагч, гүйцэтгэгчийн зүгээс хаягдлыг ачих, цуглуулах, тээвэрлэх, бохир усыг цэвэрлэх, зайлуулах мөн ялгадасны лагийн менежментийг гарган ажиллана.
- 12.1.5. Бохир задлагч, үнэр дарагч бодисыг стандартын дагуу хэрэглэнэ.

## **12.2. БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА**

- 12.2.1. Түр ариун цэврийн байгууламжийн бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар мөн эвдэрсэн нөхцөлд солих буюу засварлахад энгийн байвал зохино.
- 12.2.2. Түр ариун цэврийн байгууламжид нөлөөлөх салхины хурд, салхины ба цасны ачааллыг тооцож бат бэх хийвэл зохино /БНБД 2.01.01-93, БНБД 2.01.07-90/.
- 12.2.3. Шалыг халтирдаггүй материалаар хийвэл зохино.
- 12.2.4. Түр ариун цэврийн байгууламжийг цельсийн -10 градусаас хүйтэн нөхцөлд гадна орчинд хэрэглэхгүй байвал зохино.

## **12.3. БЭХЭЛГЭЭ СУУРИЛУУЛАЛТ**

- 12.3.1. Барилгын ажлын явцад ашиглах түр барилгын хэмжээ хүрэлцээ нь барилгын ажлын цар хүрээг бүрэн хангах хэмжээнд байх бөгөөд ажил дууссаны дараа бүрэн нүүлгэн шилжүүлнэ.
- 12.3.1. Барилгын ажил дууссаны дараа түр барилга байгууламжийг нүүлгэх бөгөөд гарсан хог хаягдлыг заавал зайлуулна.
- 12.3.2. Түр ариун цэврийн байгууламжийн арчлалтыг хариуцах үйлчилгээний компаниудтай гэрээ хийж, гүйцэтгэлийн стандартыг мөрдөж ажиллавал зохино.


## **12.4. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ХАНГАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ**

### 13. АЧАА ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА /МАШИН МЕХАНИЗМЫН ДУГУЙ УГААХ/

Барилгын үйлдвэрлэлд бэлтгэх ажлын хүрээнд, барилгын ажил гүйцэтгэх нөхцөл, байдалтай танилцсаны үндсэн дээр барилгын ажилд том оврын ачаа тээврийн машин механизмын дугуй угаах замаар авто замын тоосжилт, эвдрэл гэмтлийг бууруулах, орчны бохирдол, ажилчдын болоод ойр ормын иргэдийн эрүүл аюулгүй байдлыг хангах зорилготой. Барилгын төвөгшил, барилгын ажил эхлүүлэх хугацаанаас хамаарч 2 төрлөөр угааж болно.



1-р арга



2-р арга

Зураг 16. Ачаа тээврийн үйл ажиллагааны аюулгүй байдлын ерөнхий шаардлага /Машин механизмын дугуй угаах 2 төрөл/

Аюулгүй байдал хангах хийц бүрэн хийгдсэн, шаардлага хангаж байгаа бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ

Хүснэгт №9. Шалгуур үзүүлэлтүүд

№	Үндсэн шаардлага	Тийм	Үгүй
1	Машин механизмын дугуй угаах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг стандартын дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Машин механизмын дугуй угаах төрлөөс хамаарч ашиглалтын хугацааны төлөвлөгөө гаргасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлд бүртгэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Барилгын талбайн эмх замбараагүй байдал, тоосжилтын хэмжээ их байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Зөөврийн машин механизмын дугуй угаах тоног төхөөрөмжийн өдөр тутмын арчлалт, эдэлгээний байдал	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>



## ХАВСРАЛТ. БАРИЛГЫН ТАЛБАЙН ХОГ ХАЯГДАЛ БОЛОН ОРЧНЫ БОХИРДОЛ



*Барилгын хог хаягдал болон орчны бохирдлын менежментийн төлөвлөгөөний үндсэн бүтэц*





**ХАВСРАЛТ: БАРИЛГЫН ХАМГААЛАЛТЫН ХҮРЭЭ, ХАШЛАГА**



**БАРИЛГЫН ХАМГААЛАЛТЫН ХААЛТ**





**ХАВСРАЛТ. БАРИЛГЫН ТАЛБАЙН ТҮР ХАШАА**



*Барилгын түр хашаа /Суурьтай/*



*Барилгын түр хашаа /Суурьгүй/*

**ЯВГАН ЗАМЫН САРАВЧ**





ХАВСРАЛТ. БАРИЛГЫН ТАЛБАЙН АХУЙН ТҮР БАРИЛГА /БИЕ ЗАСАХ ГАЗАР/



*Зөөврийн ариун цэврийн байгууламжийн тээвэрлэлт*



*Зөөврийн ариун цэврийн байгууламжийн ашиглалт*



**ХАВСРАЛТ. АЧАА ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ШААРДЛАГА /МАШИН МЕХАНИЗМЫН ДУГУЙ УГААХ/**



*Машин механизмын дугуй угаах 1-р арга:  
Зөөврийн автомат тоног төхөөрөмж ашиглан усаар тоос шороог шүршиж арилгах*



*Машин механизмын дугуй угаах 2-р арга  
Механик гар аргаар даралтат усаар тоос шороог шүршиж арилгах*